



НИЙСЛЭЛИЙН  
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2013 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 5173

Улаанбаатар хот

Захирамжийн хэрэгжилтийг хангах тухай

Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/931 дүгээр захирамж, Агаарын чанарын албаны дотоод журмын 4.11 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн гэр хорооллын дулаан алдагдалтай байшин, дулаалга багатай гэрт амьдардаг айл өрхийн өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, орон сууцаа дулаалах зорилготой “Дулаалгын аян зохион байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/931 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн хэлтэс /Г.Баярхүү/-т даалгасугай.

2. Захирамжаар батлагдсан аяны үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

3. Хавсралтаар батлагдсан зардлын задаргааг үндэслэн санхүүжилт олгохыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Ч.БАТСАЙХАН



**“ДУЛААН, ЭРҮҮЛ ОРЧИНД ХЭМНЭЛТТЭЙ АМЬДАРЦГААЯ” АЯНЫ  
ХҮРЭЭНД ОРОН СУУЦ, ГЭР ХОРООЛЛЫН ӨРХҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ЗАДАРГАА**

№	Зардлын нэр	Задаргаа	Тоо хэмжээ	Нэгж зардал /төгрөг/	Төсөв /төгрөг/
1.	Сурталчилгааны материал бэлтгэн хэвлүүлэх	A5 –аар 4 хуудастай өнгөтөөр	10 000	970	9 700 000
2.	Өдөр тутмын болон зар мэдээний чиглэлийн сонин сэтгүүлд мэдээлэл бэлтгэн гаргах	“Улаанбаатар таймс” сонинд хагас нүүр мэдээлэл	1	360 000	360 000
		“Зууны мэдээ” сонинд хагас нүүр ярилцлага	1	320 000	320 000
		Өнгөтөөр 1 нүүр өдрийн сонинны амралтын дугаарт	1	520 000	520 000
3.	“Дэлхийн хот Улаанбаатар” нэвтрүүлэг	Шууд нэвтрүүлэгт оролцох	1	2 000 000	2 000 000
4.	Эрчим хүч хэмнэх талаар нэвтрүүлэг бэлтгэх	4 төрлийн богино хэмжээний сурталчилгааны бичлэг	4	450 000	1 800 000
5.	Бэлтгэсэн сурталчилгааны бичлэгийг арилжааны телевизээр цацах	TV 8 –ээр	1	270 000	270 000
		TV9-ээр	1	270 000	270 000
		MN25-ээр	2	270 000	540 000
6.	Нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулагдах сургалт сурталчилгааны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах зардал	Сурталчилгааны хулдаас нь самбар хэвлүүлэх зардал /4*6/	24	12 000	288 000
		Нээлтийн үйл ажиллагаанд ашиглах дэлгэц, хөгжим түрээслэх зардал	9	180 230	1 622 000
		Сургалт сурталчилгааны нээлтийн үйл ажиллагааг хөтлөх хөтлөгчийн зардал	6	45 000	270 000
7.	Дүүргүүдэд сургалт зохион байгуулах ажлын хэсгийн тээврийн хэрэгслийн шатахууны зардал	Багануур, Налайх, Багахангай дүүргүүдэд нээлтийн үйл ажиллагаа болон сургалт нэг удаа, төвийн 6 дүүрэгт нээлтийн үйл ажиллагаа тус бүр 1 удаа, сургалт 11 удаа зохион байгуулагдах зарцуулагдах зардал	20	71 000	1 420 000
8.	Сургалт зохион байгуулах багшийн зардал	Барилга эрчим хүчний хэмнэлтийн төвийн зөвлөх багш Б.Мөнхбаяртай хамтран сургалт зохион байгуулах	15	40 000	600 000
<b>НИЙТ ДҮН</b>					<b>19 980 000</b>